


“yerú” ХЭМЭЭХ ҮГИЙН ГАРАЛ

М. Базаррагчаа *

Толь бичгүүдэд “yerú” (ep) хэмээх үгийн утгыг “1. энгийн, жирийн, 2. тоймдоо” гэсэн гол утгатай бөгөөд “угаасаа, огт, ямагт, үргэлж” гэсэн салаа утгатай юм. Харьяалах, гарах, өгөх-оршихын тийн ялгалаар хувилж, “yerú-yin” (ерийн), yerú-ēce (ерөөл), yerú-degēn (epдөө)” гэж бүтэх боловч “энгийн, угаасаа, ерөнхийдөө” гэсэн тэмдэг нэр iú оруулсан үгийн утга илтгэх болжээ. Өгөх-оршихын “-de” нь “marγāsi-da (маргаашид), dorγūsi-da (дорогшид), Јаqa-da (захад), ūrgelјiqamtu-da (хамтад), Јerge-de (зэрэгд), yeke-de (ихэд) зэрэг үгнээ даган орж, язгуур үндсийн утгын дагуу “лавшруулах, үргэлжлэх” гэсэн утгыг нэмдэг.

“yeri-yin Јam ~ yerúde-yin Јam, yerú-yin ~ yerúde-yinamidural, yerú-yinкereg ~ yerú-de-yinкereg” гэхэд “-de”-гүй байх нь утгын хувьд нэг их ялгаа байхгүй боловч “yerú-yin kóske” (энгийн хөсөр), yerú-de-yin kóske (бод малын хөсөг) гэвэл ялгаатай юм. Энэ үгээс



гэх мэт тайлбарлажээ. Ш.Цэцэнцогт “yerúјir” хэмээх үгийг нэг гаралтай¹ гэсэн байна. Г.Д.Санжеев јirum (журам), dūrim (дүрэм) хэмээх үгийн анхдагч хэлбэрийг \sqrt{diru} – гэж сэргээгээд, энэ нь “јiru- (зурах), јirum (зурам-үсгийн зурам)² хэмээх үг болохыг тодорхойлжээ. Тэрээр, “d” нь “ј”, улмаар “у” болон сэлгэдгийг **man.dasa-**, **mon.jasa-**, **oirad**, **ordus.yasa-**, **doγūduúde:jaha-**, **tur.jasa-**, **mon.jasaγūl**. **orus. ecayl; mon.jam, orus.ямщик**” гэх мэт жишээгээр үзүүлсэн байх ба Јагуγа, Јarliγ, Јасаγ” зэрэг үгийг “ярыга, ярыжник, ярлык, япак” гэсэн хувилбартайг дурдсан байна. Мөн “adaγ” хэмээх үг тува хэлнээ “adak”, хакас хэлнээ “azak”, киргиз хэлнээ “ajak”(хөл); “deleng” гэсэн үг нь **man.delen**, **tatar. јilin**, **uzbek. јelin**, **ebenc**. “didan” гэж “d, ј, у” гийгүүлэгч сэлгэдэг

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Хэл шинжлэлийн тэнхим

¹ Ш.Цэцэнцогт, *Монгол үгсийн язгуурын толь*, Жанг Жияа Кеү, 1988, 2480-р т.

² Г.Д.Санжеев, *Сравнительная грамматика монгольских языков*, I, 1953, стр.109

байна. Б.Я.Владимирцов “Jigu-” хэмээх үгийг “Jurbus”-тай гарал нэг гээд, Осм.yaz-, Кар., Крм., jaz-, Кир.жаз- (бичих, зурах), якут.суруй- (бичих), Мджр.nigu- (зурах)³ гэж харьцуулсан бөгөөд “j” нь “y, s, n” зэрэг гийгүүлэгч сэлгэдэг гэж үзсэн ба А.В.Дыбо “Jigu-” (зурах) нь түрэг хэлний “jaz/ čiz-”, түнгүүс манж хэлнээ “nigu-” гэж харьцуулаад, нийт алтайн хэлнээ “*nigu-” (зурах) гэж сэргээсэн байна⁴. Е.В.Сундуева буриад хэлний “юрье-(сргөх хөдлөх) хэмээх үгийг “yerü, yerüngkei” хэмээх үгтэй холбож, энэ хоёр үгийн “-ru” үе-утгалбарыг “-nar” (олон тооны дагавар), narmai (нармай) хэмээх үгийн “r”-тэй “олны утгаараа” холбоотой ба “sürüg” (сүрэг), (сэрвэн сэрвэн- юм алсаас жирвэлзэх, өт язганах), манж хэлний “sor сэмэ” (олон, бөөн, өтгөн, элбэг, сүрэг) гэсэн үгсийн “r”-тэй холбон үзжээ⁵.

Дээр дурдсан düri (дүр) хэмээх үг нь düri-m (дүрэм), düri- sü (дүрс)~dür- sü (дүрс) гэсэн үг бүтэхийн зэрэгцээ dura (хүсэл сонирхол), durāyi- (дурайх- тодрох), durala- (дурлах- хайрлах), dura-s- (дурсах- өнгөрснийг дурайтал санах), dura-d- (дурдах- өнгөрснийг өгүүлэх нь, санамж), dura-n (дуран- алсыг дурайтал тодруулан харах хэрэгсэл, **uig, tur.durbun, pers.durbin**) хэмээх үгс “ü~u”-гийн сэлгэцээр ялгарчээ. Ш.Цэцэнцогт “düri ~ dura” гэж сэлгэсэн⁶ хэмээн үзсэн нь зөв юм. Юу гэвэл, durāyi- (дурайх) гэдгийн “du” нь “ju”-тай сэлгэж, “jurāyi-” (зурайх), Jurbus (зурвас-урт нарийн журам, баримт хуудас), Jigu- (зурах), Jigu- m (журам-нарийн ширдэг, дүрэм журам, шугам зураас), Jura- та (зурам- мэрэгч амьтан) хэмээх үгс үүссэн нь “dūrisü, düri” хэмээх үгийн “янз байдал, тухайлбал, юмсын гадаад зах ирмэг буюу хязгаар нь уг юмсын дүр дүрсийг бий болгодогтой холбогдоно.

Б.Я.Владимирцов “dü-ri” хэмээх үгийг алтайн төрөл хэл **уйг**. túz (гадаад байдал, өнгө, дүрс), **кир**. túg (эсгийн дээр ширсэн эрээн мяраан зураг)⁷ гэхчлэн харьцуулснаас үзвэл, “dü” нь түрэг зүгийн хэлнээ “tü-”, “r/ i” нь “z” болон сэлгэсэн боловч утга нэг байсны улбааг хадгалсаар иржээ. Энэхүү “dü-r/i” гэсэн хоршмол үе-утгалбараар бүтсэн “dü-ri” (дүр) хэмээх үг нь дараах дүрслэх үйл үгээс эхтэй болно. Тухайлбал,

da-rā-yi- (дарайх) → √b: da-r-bā-yi- (дарвайх), √d: da-r-dā-yi- (дардайх)
 du-rā-yi- (дурайх) → √b: du-r-ba-lja- (дурвалзах- дур булгих),
 do-rū-yi- (доройх) → √b: do-r-bū-yi- (дорвойх), √d: do-r-dū-yi- (дордойх)
 de-re-yi- (дэрийх) → √b: de-r-be-yi- (дэрвийх), √d: de-r-de-yi- (дэрдийх)
 dō-rū-yi- (дөрийх) → √b: dō-r-bū-yi- (дөрвийх), √d: dō-r-dū-yi- (дөрдийх)
 dü-re-lje- (дүрэлзэх) → √b: dü-r-be-lje- (дүрвэлзэх)
 √s: da-r-sā-yi- (дарсайх), √l: da-r-la-yi- (дарлайх, дарлийх)
 √s: do-r-su-yi- (дорсойх)

³) Б.Я.Владимирцов. *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Лгр., 1929, стр. 188

⁴) А.В.Дыбо. *Семантическая реконструкция в алтайской этиологии*, Соматические термины (плечевой пояс), М., 1996, стр.14

⁵) Е.В.Сундуева. *Звуки и образы*, Фоносемантическое исследование лексем с корневыми согласными [r/m] в монгольских языках, Улан-Удэ, 2011, стр.206-207

⁶) Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 1988, 2162, 2159-2140-р т.

⁷) Б.Я.Владимирцов. Дурдсан зохиол, 1929, стр. 165

\sqrt{s} : de-r-se-yī- (дэрсийх), \sqrt{m} : de-r-me-yī- (дэрмийх) → \sqrt{l} : de-r-le-yi- (дэрлийх)

\sqrt{s} : dǒ-r-sǔ-yī- (дэрсийх)

гэх мэтээр дэд үе-утгалбар “ra”-гийн завсар “b, m, l, d, s” гэсэн оруулбар бүтээвэр шурган орж, дээрх дүрслэх үгсийг бүтээжээ. Эдгээр дүрслэх үгсийн “da...” үе-утгалбар нь “ja...” үе-утгалбараар сэлгэж,

ja-rā-yi- (зарайх) → \sqrt{b} : ja-r-bā-yi- (зарвайх)

ju-rā-yi- (зурайх) →

\sqrt{m} : je-r-me-yī- (зэрмийх)

ji-rā-yi- (жарайх) → \sqrt{b} : ji-r-ba-yi- (жарвайх); \sqrt{m} : ji-r-mā-yi- (жармайх, анийх)

ji-rī-yi- (жирийх) → \sqrt{b} : ji-r-bi-yī- (жирвийх); \sqrt{m} : ji-r-mi-yī- (жирмийх) зэрэг үг салаалжээ. “daḡāyi-”-аас “daḡāyā(дэс дараа), daḡama(дарам-амьтны нуруу дагуу газар), “durāyi-”-аас “dura(дур зориг), duran/g (дуран авай), “dōḡūyi-”-аас “dōḡiḡūn”(дориун-сүрхий), daḡiḡūn(дариун-сүрхий, чанга, сайхан), dorbi(дорви- хүч чадал), “deḡeyī-”-ээс “deḡe”(дэр), deḡe(дэргэ, дэргэд, зэрэг), “dōḡūyi-”-ээс “dōḡū”(дөр-хамагч мод, анжисны гох төмөр, суулганы сэнж, усны гарам), dōḡūbci(дөрөвч-үхрийн ногт), “jaḡāyi-”-аас “jaḡāyā(зараа), jīḡūyi-”-ээс “jīḡim”(жирэм- олмыг горхилох гөрмөл сур), “jīḡuḡā”(жороо-хаа гуя хоёр жигд хурдан алхах), jīḡu-(зурах), jīḡum(журам), jīḡūke(зүрх) зэрэг үгс үүсжээ. Ш.Цэцэнцогт dūḡū-(дүрэх) хэмээх үгээс dōḡūḡē(дөрөө), dōḡū(дөр), dōḡūbci(дөрөвч), dōḡūlji(дөрөлж) зэргийг гарал нэг⁸ гэжээ. Н.Поппе dūḡū- (дүрэх-шургуулах, хөндлөнгөөс хөлөө дүрэх, хөрөнгө оруулах, өрж тавих), dōḡūḡē (дөрөө), солоон хэлнээ “dḡrḡḡki”, эвенк хэлнээ “durḡki ~ durikī (id.)”, чуваш хэлнээ “jḡrana < *ūrāḡi < *jūrāḡi (id.), тэлэнгэд, куман хэлнээ “üzāḡi,üzāḡä (id.)” гэж харьцуулаад, “dōḡūḡē” хэмээх үгийг “dūḡū-” хэмээх үгээс үүсэлтэй⁹ гэжээ. Тэрээр, “dōḡūḡē” нь “dūḡūḡē” гэдгээс “ö~ü”-гийн сэлгэцээр ялгарсан гээд, эртний хэлбэрийг “dūḡeḡē” гэж сэргээн босгосон байна. “dōḡū” буюу “dōḡūbci” нь “уг юманд багтахуйц нарийн урт зүйл байх тул дөрөөнд хөл багтах” гэсэн утгаас “dōḡūḡē ~ dūḡūḡē” хэмээх үг салаалжээ. Ийнхүү “багтах багтаах” нь “зэрэгцэх” утгыг агуулахаас гадна ойрд аялгуунд “1. тавих, өрөх, дүрэх, 2. нуух, далдлах, 3. халуу оргих, сэрүү оргих” гэхийг халуу дүрэх, сэрүү дүрэх” гэж хэлдэг байна¹⁰. Г.И.Рамстедт солонгос хэлнээ “dōḡū, dōḡebci, dūḡi, dūḡim, dūḡsūn” зэрэг үгийг “-tturi, -turi” гэсэн дагавартай харьцуулжээ¹¹.

Мөн “dūḡim”(дүрэм)-ээс үүсэлтэй “jīḡum”(журам) хэмээх үгийн эхний хоёр үе-утгалбарыг байр сэлгэвэл “режим” (журам, дэглэм, ёс) хэмээх үг бүтжээ. “dūḡim” хэмээх үгийн “ü~i” гэсэн хоёр эгшгийн байр сэлгэж бүтсэн тул анхдагч хэлбэр нь diḡum(дүрэм), dīḡum(дүрэм) гэж байсан ба “i~i” эгшиг сэлгэснээс ji-ru- (зурах), yeḡū(er) хэмээх үг бүтсэний “yeḡū” нь “шулуун зураасаас бүтэх” дүр (dūḡi, dūḡsū)-ээс үүсэлтэй

⁸) Ш.Цэцэнцогт, *Монгол үгсийн язгуурын толь*, Жанг Жияа Кеү, 1988, 2150-2151, 2162-2163-р т.

⁹) Nicolaus Poppe, *Vergleichende Grammatik der altaischensprachen*, 1960, p.23, 82

¹⁰) Б.Х.Тодаева, *Словарь языка ойратов синьцзяна*, Элиста, 2001, стр.138

¹¹) G.J.Ramstedt, *Studies in Korean etymology*, Helsinki, 1949, p.277

юм. Учир нь, “уг юмын дүр, дүрс нь ихэд хийсвэр тул түүнээс үүссэн “yerü” хэмээх үг нь “хийсвэр, ерөнхий” утгатай үг болон хувирчээ.

“dūri-m”(дүрэм) хэмээх үг нь ĵisü-m (зүсэм), iniyēd(ü)-m (инээдэм), qaniyād(u)-m (ханиадам), qaqa-m (харам харуусал), oġu-m (ором), eġci-m (эрчим) гэх мэтээр нэрээс нэр бүтээх дагавартай адил аргаар бүтсэн ба “yerü” (ep) хэмээх үг нь “dīru-m, dūri-m” (дүрэм), ĵīgu-m (журам) хэмээх үгээс салаалсан байна. Ш.Цэцэнцогт “ĵig” (жир, жирийн) хэмээх үгнээ төвд хэлний “spruig” хэмээх үгийг хадсан боловч “yerü” хэмээх үгтэй гарал нэг байж мэднэ¹² гэжээ. Харин “yerü” хэмээх үгнээ “багаж хэрэгсэл” гэсэн утга бүхий “-m/ndeg” хэмээх дагавар залгаж, “Өвчний **ерөндөг** эм, мунхгийн **ерөндөг** эрдэм” гэсэн хэлц цогцолборт тохиолдох “yeründeg”(ерөндөг- өвчнийг номхотгогч) хэмээх үг бүтжээ.

“ĵīgu-” хэмээх үг нь “тухайн юмыг зурах, улмаар тэр зураас нь уул юмыг хоёр хуваах” гэсэн утга бүтээж, “yeründeg” гэдгээс “эсрэг тэсрэг хоёр этгээд” (ерөндөг хүн) гэсэн утга салаалжээ. “ĵi-gu-” (зурах) хэмээх үгийн “i” нь “u”-тай сэлгэж, ĵa-gu- (зарах хүн зарах, ухаан зарах, морь зарах) хэмээх үг бүтсэн ба ĵi-gu-γ (зураг- дүрслэн зурсан нь, зураг төөрөг), ĵa-gu/a-γ (зараг- хэрэгсэл, зардал, хэрэг зарга) хэмээх үг салаалсан аж. Үүнчлэн “ĵo-gi-γ”(зориг-зорилгодоо хүрэх), ĵo-g/u- (зорох- уртааш нь “зурж” өөлөх), ĵö-gi- (зөрөх- үл дагах, зөрчих), ĵö-gi-g (зөрөг-нарийн цуваа зам, газар хагарч хоёр ирмэг нь зөрөх), ĵi-gi-m (жирэм-олом чангалах гөрмөл сур) зэрэг эгшгийн сэлгэцээр бий болжээ. Иймээс “yerü/mdeg”(ерөндөг, ерөмдөг) хэмээх үг нь ямар нэг юмыг “зорох мэт, ярах мэт уртааш нь эвдэх” гэсэн утгатай тул “хувцсандаа ерөндөг, мунхагт ерөндөг, өвчинд ерөндөг” гэж хэлэлцдэг байна.

РЕЗЮМЕ

Если рассмотрим со стороны плана выражения, слова “yerü” (обычно, вообще, обычный) образованы от слов “dūri, dūr/isü”(образ, изображение, форма) и “ĵīgu-”(÷ертить, рисовать) в результате чередования звуков “d~ĵ~y”. А в плане содержания вышеуказанные слова “yerü” (вообще), yerüngkei(общий, главный) возникли путем разветвления от изобразительных глаголов “durāyi-”(виднеться отчётливо, представляться образно) и ĵugāyi- (вырисовываться, виднеться). От интра-образных слов “durāyi-, ĵugāyi-” в корне, которых чередуются гласные звуки, путём семантической филиации образуются двуслоговые имена и глаголы:

durāyi-(виднеться отчётливо)→ dura(желание), duran/g (бинокль)

dörüyi-(делать заскорузлым)→ dörü(волосьянье кольцо, продеваемые в нос быка),

dörügē(стремя), dörülĵi(седловина)

doguyi-(высовываться, торчать)→ dogüi(слабый, неспособный)

¹²⁾ Ш.Цэцэнцогт. Дурдсан зохиол, 1988, 2403-рт.

dereyī-(оттопыриваться)→dere(подушка)

dūrūļe-(вспыхивать, воспламеняться)→dūrū- (макать во что либо)

ĵarāyi- (ёжиться)→ĵagaγā(ёж)

ĵugāyi- (вырисовываться)→ĵīgi-(чертить), ĵog/u- (строгать)

ĵōgi-(разъехаться), ĵogi-(стремиться), ĵagi-(использовать для услуг, продавать)

Выясним полисемию вышеназванных примеров: слова “ĵogi-(стремиться), ĵīgi-(рисовать), ĵagi-(продавать, распоряжаться, отправлять), ĵog/u-(обстручивать), ĵōgi-(разминуться) возникли от слова “ĵugāyi-“(вырисовываться), которые содержит значение “удаляться становясь узким”, от слова “dugāyi-(виднеться отчетливо), имеющего значение “восстановливать себе в памяти давно прошедшее”.